# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Хөвсгөл аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан**

**Аудитын код: ХӨА-2026/144/НА-СТА-ТШЗ**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум<br>2025 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Б.Даваанямь<br>Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс 7038-2797, Цахим шуудан khovsgol@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.11 № 01/55

танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Х.ИДЭР ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 82,395.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 360.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, худалдан авсан, үнэ төлбөргүй 98,939.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл хүлээн авч нийт 181,694.9 мянган төгрөгийн хөрөнгийн шинэчлэлийг хийсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар худалдан авах ажиллагааны тухай хууль, журмыг бүрэн мөрдөж ажиллаагүй, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бүрэн бүрдүүлээгүй, захиалагчийн хяналтын зардлыг байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын даргаар батлуулан 4 зорилт, 121 арга хэмжээний хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулж 86.0 хувийн үнэлгээтэй хэрэгжүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 312,954,787.14 | 293,104,413.38 |
| 33 | АВЛАГА | 238,117,834.80 | 198,959,961.04 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,952,471.00 | 0 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 218,894,660.80 | 198,959,961.04 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 15,270,703.00 | 0 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 74,836,952.34 | 94,144,452.34 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 27,391,242.80 | 29,342,242.80 |
| 35400 | Хангамжийн материал | 47,445,709.54 | 64,802,209.54 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14,700,974.66 | 21,350,674.66 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,877,912.27 | 7,877,912.27 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 4,556,367.61 | 7,321,367.61 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,200,000.00 | 3,507,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 54,025.00 | 549,625.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,056,430.00 | 24,195,630.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 856,962,451.28 | 983,133,037.79 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 856,962,451.28 | 983,133,037.79 |
| 39200 | Биет хөрөнгө | 806,962,451.28 | 933,133,037.79 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 611,406,306.95 | 611,406,306.95 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -69,457,847.32 | -82,534,057.47 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 232,091,750.00 | 232,091,750.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -181,758,416.47 | -207,131,750.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 553,144,736.81 | 551,736,086.81 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -374,294,603.21 | -221,256,392.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 75,484,270.00 | 100,697,520.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -58,820,384.51 | -65,845,149.01 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 36,299,900.00 | 36,299,900.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -17,133,260.97 | -22,331,177.49 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 50,000,000.00 | 50,000,000.00 |
| 39301 | Програм хангамж | 2,530,000.00 | 2,530,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,530,000.00 | -2,530,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 50,000,000.00 | 50,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 1,169,917,238.42 | 1,276,237,451.17 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 3,013,760.00 | 0 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 3,013,760.00 | 0 |
| 41300 | Өглөг | 3,013,760.00 | 0 |
| 41360 | Бусад өглөг | 3,013,760.00 | 0 |

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3,013,760.00 | 0 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,166,903,478.42 | 1,276,237,451.17 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,166,903,478.42 | 1,276,237,451.17 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 215,142,362.40 | 215,142,362.40 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 215,142,362.40 | 215,142,362.40 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 768,389,589.61 | 877,723,562.36 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -822,041,357.11 | 768,389,589.61 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,590,430,946.72 | 109,333,972.75 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 183,371,526.41 | 183,371,526.41 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 1,169,917,238.42 | 1,276,237,451.17 |

## Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 3,631,812,148.85 | 2,135,424,848.04 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,798,503,263.60 | 2,135,424,848.04 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,798,503,263.60 | 345,012,986.04 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 248,730,917.30 | 198,959,961.04 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 248,730,917.30 | 198,959,961.04 |
| 120009 | Бусад орлого | 0 | 47,113,125.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 1,425,574,363.76 | 98,939,900.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 124,197,982.54 | 0 |
| 122 | Тусламжийн орлого | 0 | 1,790,411,862.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0 | 1,790,411,862.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0 | 1,603,274,100.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0 | 1,598,892,900.00 |
| 122112 | Хөрөнгийн санхүүжилтийн орлого\\ | 0 | 4,381,200.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0 | 187,137,762.00 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0 | 187,137,762.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,833,308,885.25 | 0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,628,232,000.00 | 0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,628,232,000.00 | 0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 203,710,068.00 | 0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 203,210,068.00 | 0 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 1,366,817.25 | 0 |

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| 133003 | Хөрөнгийн | 1,366,817.25 | 0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,041,381,202.13 | 2,026,090,875.29 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,041,381,202.13 | 2,026,090,875.29 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,876,556,832.56 | 1,954,766,970.91 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,257,276,640.74 | 1,340,118,538.90 |
| 210101 | Үндсэн цалин | 728,131,511.71 | 713,350,875.40 |
| 210102 | Нэмэгдэл | 391,641,489.03 | 512,103,112.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 78,434,540.00 | 53,590,812.60 |
| 210104 | Урамшуулал | 59,069,100.00 | 61,073,738.77 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 157,327,942.44 | 172,905,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 106,605,292.49 | 116,076,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 12,653,569.44 | 14,207,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 6,484,656.75 | 7,103,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 6,316,884.79 | 7,103,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 25,267,538.97 | 28,414,400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,961,066.52 | 36,020,224.79 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,224,306.22 | 4,629,623.29 |
| 210302 | Түлш, халаалт | 20,735,266.80 | 29,532,591.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,001,493.50 | 1,858,010.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 134,818,694.45 | 128,002,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 59,959,324.25 | 73,591,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 59,400,000.00 | 53,080,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 475,700.00 | 681,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 588,880.00 | 649,950.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 14,394,790.20 | 0 |
| 2105 | Нормативт зардал | 7,243,000.00 | 0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,243,000.00 | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 60,378,600.00 | 91,466,425.93 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 1,345,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0 | 9,999,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 60,378,600.00 | 80,122,425.93 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 75,809,600.00 | 75,046,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 75,809,600.00 | 75,046,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 17,259,809.08 | 40,696,181.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,259,809.08 | 40,696,181.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 139,481,479.33 | 70,511,299.49 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,474,989.12 | 14,186,986.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0 | 800,000.00 |

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 108,006,490.21 | 55,524,313.49 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 164,824,369.57 | 71,323,904.38 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0 | 32,337,004.38 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0 | 32,337,004.38 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 0 | 32,337,004.38 |
| 2131122 | Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 0 | 27,102,943.38 |
| 2131123 | Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал | 0 | 5,234,061.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 162,548,400.00 | 38,986,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,200,000.00 | 0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 160,348,400.00 | 38,986,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,275,969.57 | 0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,337,807.57 | 0 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 938,162.00 | 0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 1,590,430,946.72 | 109,333,972.75 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 1,590,430,946.72 | 109,333,972.75 |

## Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 2,035,492,812.08 | 2,067,309,150.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 45,060,338.00 | 2,067,309,150.80 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 45,060,338.00 | 47,113,125.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 45,060,338.00 | 0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 45,060,338.00 | 0 |
| 120009 | Бусад орлого | 0 | 47,113,125.00 |
| 122 | Тусламжийн орлого | 0 | 2,020,196,025.80 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0 | 2,020,196,025.80 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0 | 1,598,892,900.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0 | 1,598,892,900.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 0 | 421,303,125.80 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0 | 421,303,125.80 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,990,432,474.08 | 0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,628,232,000.00 | 0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,628,232,000.00 | 0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 362,200,474.08 | 0 |

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 | 0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 361,700,474.08 | 0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,900,110,212.08 | 1,984,554,150.80 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,900,110,212.08 | 1,984,554,150.80 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,720,015,139.51 | 1,913,230,246.42 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,241,959,378.89 | 1,340,118,488.90 |
| 210101 | Үндсэн цалин | 650,647,373.74 | 713,350,825.40 |
| 210102 | Нэмэгдэл | 454,287,905.15 | 512,103,112.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 77,755,000.00 | 53,590,812.60 |
| 210104 | Урамшуулал | 58,269,100.00 | 61,073,738.77 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 1,000,000.00 | 0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 173,114,300.50 | 172,905,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 123,466,600.50 | 116,076,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 12,411,900.00 | 14,207,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 6,206,000.00 | 7,103,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 6,206,000.00 | 7,103,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 24,823,800.00 | 28,414,400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 20,787,732.15 | 35,361,699.72 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,140,160.15 | 3,971,098.22 |
| 210302 | Түлш, халаалт | 15,659,700.00 | 29,532,591.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,987,872.00 | 1,858,010.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 71,133,300.00 | 122,767,153.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 27,468,700.00 | 69,048,403.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,400,000.00 | 53,387,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 144,600.00 | 331,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 56,847,500.00 | 75,806,551.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,060,000.00 | 10,590,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0 | 9,999,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 46,787,500.00 | 55,217,551.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 73,021,600.00 | 73,446,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 73,021,600.00 | 73,446,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,782,739.85 | 57,177,160.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,782,739.85 | 57,177,160.80 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 58,368,588.12 | 35,647,793.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 58,368,588.12 | 32,397,793.00 |

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0 | 3,250,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 180,095,072.57 | 71,323,904.38 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0 | 32,337,004.38 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0 | 32,337,004.38 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | 0 | 32,337,004.38 |
| 2131122 | Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\\ | 0 | 27,102,943.38 |
| 2131123 | Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\\ | 0 | 5,234,061.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 162,548,400.00 | 38,986,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,200,000.00 | 0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 160,348,400.00 | 38,986,900.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 17,546,672.57 | 0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,337,807.57 | 0 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 16,208,865.00 | 0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 135,382,600.00 | 82,755,000.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 135,382,600.00 | 82,755,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 135,382,600.00 | 82,755,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 135,382,600.00 | 82,755,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 135,382,600.00 | 82,755,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -135,382,600.00 | -82,755,000.00 |

## Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Устгалын өмнөх | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1.1 Засгийн газрын оруулсан капитал | 1.2 Дахин үнэлгээний нөөц | 1.3 Хуримтлагдсан үр дүн | 1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 215,142,362.40 | 183,371,526.41 | -822,041,357.11 | -423,527,468.30 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 215,142,362.40 | 183,371,526.41 | -822,041,357.11 | -423,527,468.30 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 1,590,430,946.72 | 1,590,430,946.72 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 215,142,362.40 | 183,371,526.41 | 768,389,589.61 | 1,166,903,478.42 |
| 11 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 215,142,362.40 | 183,371,526.41 | 768,389,589.61 | 1,166,903,478.42 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 215,142,362.40 | 183,371,526.41 | 768,389,589.61 | 1,166,903,478.42 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 109,333,972.75 | 109,333,972.75 |
| 20 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 215,142,362.40 | 183,371,526.41 | 877,723,562.36 | 1,276,237,451.17 |

## Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Тайлант он |
|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 421,303,125.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 421,303,125.80 |
| 122 | Тусламжийн орлого | 421,303,125.80 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 421,303,125.80 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 421,303,125.80 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 421,303,125.80 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 421,303,125.80 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 421,303,125.80 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 416,069,064.80 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 13,900,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,900,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 121,879,653.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 68,492,403.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 53,387,250.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 158,561,551.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 93,345,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 9,999,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 55,217,551.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 72,646,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 72,646,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 49,081,860.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 49,081,860.80 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,234,061.00 |

## Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан-1

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,680,983,200.00 | 1,618,903,081.62 |
| 12 | Татварын бус орлого | 1,680,983,200.00 | 1,618,903,081.62 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 52,500,200.00 | 47,113,125.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 52,500,200.00 | 0 |
| 120009 | Бусад орлого | 0 | 47,113,125.00 |
| 122 | Тусламжийн орлого | 1,628,483,000.00 | 1,571,789,956.62 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,628,483,000.00 | 1,571,789,956.62 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,680,983,200.00 | 1,618,903,081.62 |

Хөвсгөл аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,680,983,200.00 | 1,618,903,081.62 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,618,778,400.00 | 1,579,916,181.62 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,365,349,700.00 | 1,340,118,488.90 |
| 210101 | Үндсэн цалин | 713,417,600.00 | 713,350,825.40 |
| 210102 | Нэмэгдэл | 528,831,500.00 | 512,103,112.13 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 61,419,600.00 | 53,590,812.60 |
| 210104 | Урамшуулал | 61,681,000.00 | 61,073,738.77 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 172,905,400.00 | 172,905,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 116,076,600.00 | 116,076,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,207,200.00 | 14,207,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,103,600.00 | 7,103,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,103,600.00 | 7,103,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,414,400.00 | 28,414,400.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,213,300.00 | 21,461,699.72 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,633,300.00 | 3,971,098.22 |
| 210302 | Түлш, халаалт | 15,615,900.00 | 15,632,591.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,964,100.00 | 1,858,010.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,897,100.00 | 887,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,246,600.00 | 556,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 257,600.00 | 331,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 392,900.00 | 0 |
| 2105 | Нормативт зардал | 32,100.00 | 0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 32,100.00 | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 37,500.00 | 0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0 | 0 |
| 210604 | Урсгал засвар | 37,500.00 | 0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 800,000.00 | 800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 800,000.00 | 800,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18,793,100.00 | 8,095,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,499,700.00 | 8,095,300.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,993,000.00 | 0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,300,400.00 | 0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,750,200.00 | 35,647,793.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,500,200.00 | 32,397,793.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,250,000.00 | 3,250,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 62,204,800.00 | 38,986,900.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 62,204,800.00 | 38,986,900.00 |

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,217,300.00 | 0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 38,987,500.00 | 38,986,900.00 |

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 225,775.0 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай 3 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга, ахлах нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 61,354.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулан бүртгэсэн. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас данснаас хасах шийдвэр гарсан 5,440.0 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасалт хийгээгүй
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 360.0 мянган төгрөгийн хөрөнгийг хөрөнгийн тохируулга хийж хөрөнгө оруулалтын зардлаар бүртгээгүй
- Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн төвлөрүүлэх шилжүүлэг 5,234.1 мянган төгрөгийг үндсэн, нэмэлт дансаар нь ангилан бүртгээгүй 213303 дансаар бүртгэсэн.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлсэн мөнгөний тохируулгыг хийгээгүй 27,102.9 мянган төгрөгөөр орлого зардлыг үлүү бүртгэж тайлагнасан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төлөвлөгөөг 23,217.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зэрэг алдааг аудитын явцад залруулан бүртгэсэн.

### Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн данснаас худалдан авалт хийсэн 82,755,000 төгрөгийн үндсэн хөрөнгийг тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр төсвийг жижиглэн хувааж шууд худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3."Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж ажиллах.

### 2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Захиалагчийн хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулахгүй байгууллагын эх үүсвэрийн дутагдалтай зардлыг нөхөхөд нийт хяналтын зардлын 32.7 хувь буюу 137,610.0 мянган төгрөгийг зарцуулж байгаа нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийн чанар, технологийн үйл явц, материалын чанар, хэрэгжилтийн хугацаа зэрэгт тавих хяналт хариуцлага сулрах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Энэ нь Барилгын ажлын захиалагчийн дүрмийн 2.7."Захиалагчийн санхүүжилтийн эх үүсвэр нь барилга байгууламжийн төсөвт өртөгт тусгагдсан байх бөгөөд зардлыг зориулалтын дагуу ашиглана" гэсэн заалт болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж : Захиалагчийн хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулж, хяналтыг үр дүнтэй зохион байгуулж ажиллах.

**3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал.**

Илрүүлэлт: Үйл ажиллагааны орлогоос 52,500.2 мянган төгрөг бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 47,113.1 мянган төгрөгийг бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 5,387.1 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн бүрдүүлж ажиллах.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхисон | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| НББ-ийн тооцооллын алдаа | 1 | 61,354.3 | - | - | 1 | 61,354.3 | 1 | 61,354.3 | - | - |
| **Дүн** | 1 | 61,354.3 | - | - | 1 | 61,354.3 | 1 | 61,354.3 | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Завсрын аудитаар илэрсэн зөрчил** | | | | | | | | |
| Анхан шатны баримтгүй бараа материал зарцуулсан | 1 | 2,750.0 | 1 | 2.750.0 | | | | |
| **Санхүүгийн аудиттай холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Орлого бүрдүүлэлттэй холбоотой | 1 | 5,387.1 | - | - | - | - | 1 | 5,387.1 |
| Захиалагчийн хяналтын зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй | 1 | 137,610.0 | | - | - | - | 1 | 137,610.0 |
| **Нийцлийн аудиттай холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй | 1 | 82,775.0 | - | - | - | - | 1 | 82,775.0 |
| **Дүн** | **3** | **225,772.1** | **-** | - | - | - | **3** | **225,772.1** |
| **Нийт дүн** | **4** | **228,522.1** | **1** | **2.750.0** | **-** | **-** | **3** | **225,772.1** |